



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань бадрал ОНӨ ХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/3/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг
2021 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Т. Ган-Өлзий
Утас: 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа /Есөнхангай Аудит ХХК/
Утас: 99048891

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайшанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.03.19 № 1-6/304

танай _____ -ны № _____ -г

“ЧАНДМАНЬ БАДРАЛ” ОНӨХХК-НИЙ
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ГАНЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу “Чандмань бадрал” ОНӨХХК-ний 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Чандмань бадрал” ОНӨХХК-ний 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	712,537,806.58	698,989,089.67
1.1.2	Дансны авлага	515,808,091.27	705,133,960.67
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	8,669,979.57	1,106,398.97
1.1.4	Бусад авлага	44,365,154.02	32,243,931.09
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	266,683,555.95	304,011,352.27
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	563,046.93	2,819,841.13
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,548,627,634.32	1,744,304,573.80
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,604,695,938.54	1,752,020,586.50
1.2.2	Биет бус хөрөнгө	1,957,024.34	20,541,503.73
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,606,652,962.88	1,772,562,090.23
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,155,280,597.20	3,516,866,664.03
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг	377,100.00	268,000.00
2.1.1.3	Татварын өр	651,327.67	19,735,022.60
2.1.1.4	НДШ – ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	989,865.24	0.00
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	37,841,876.41	19,663,374.61
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	3,381,076.02	2,648,580.98
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	43,241,245.34	42,314,978.19
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		

Чандмань-Бадрал ОНӨХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		117,416,135.09
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		117,416,135.09
2.2	Өр төлбөрийн нийт дүн	43,241,245.34	159,731,113.28
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	846,529,959.90	846,529,959.90
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	754,554,116.80	787,571,794.03
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	161,850,999.60	161,850,999.60
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,349,104,275.56	1,561,182,797.22
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,112,039,351.86	3,357,135,550.75
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,155,280,597.20	3,516,866,664.03

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,753,821,639.10	3,996,115,859.78
2	Борлуулалтын өртөг	2,790,903,990.92	3,064,019,529.13
3	Нийт ашиг(алдагдал)	962,917,648.18	932,096,330.65
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	22,608,874.93	43,457,702.05
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	0.00	1,706,139.28
9	Борлуулалт, маркетингийн зардал	130,628,457.94	9,615,147.76
10	Ерөнхий ба удирдлагын зардал	414,337,950.90	786,179,979.35
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	176,970,742.84	136,933.20
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	109,885.13	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	68,597.89	7,747,334.15
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	263,767,854.45	189,075,445.82
19	Орлогын татварын зардал	26,376,785.45	18,907,544.58
20	Татварын дараах ашиг (алдагдал)	237,391,069.00	170,167,901.24
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		
23	Бусад дэлгэрэнгүй орлого	237,391,069.00	170,167,901.24
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	237,391,069.00	170,167,901.24

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	846,529,959.90	754,554,116.80	161,850,999.60	1,077,575,574.76	2,840,510,651.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	34,137,631.80	34,137,631.80
Залруулсан үлдэгдэл	846,529,959.90	754,554,116.80	161,850,999.60	1,111,713,206.56	2,874,648,282.86
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	237,391,069.00	237,391,069.00
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг					
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	846,529,959.90	754,554,116.80	161,850,999.60	1,349,104,275.56	1,614,958,021.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		0.00	0.00	41,910,620.42	41,910,620.42
Залруулсан үлдэгдэл	846,529,959.90	754,554,116.80	161,850,999.60	1,391,014,895.98	3,153,949,972.28
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	170,167,901.24	170,167,901.24
Өмчид гарсан өөрчлөлт					
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	33,017,677.23	0.00	0.00	33,017,677.23
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	846,529,959.90	787,571,794.03	161,850,999.60	1,561,182,797.22	3,357,135,550.75

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,217,094,010.86	4,306,695,650.32
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,149,057,431.74	3,918,309,608.58
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	68,036,579.12	388,386,041.74
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,108,736,701.98	4,145,898,469.52
	Ажиллагчдад төлсөн	1,178,038,200.10	1,369,725,797.22
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	374,867,931.16	436,202,811.32
	Бараа материал худалданавахад төлсөн	563,836,669.38	402,479,641.50
	Ашиглалтын зардалд төлсөн	210,313,192.18	283,737,195.38
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	923,748,365.00	888,651,732.52
	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
	Татварын байгууллагад төлсөн	511,122,553.66	444,803,139.84
	Даатгалын төлбөрт төлсөн	1,900,400.00	2,614,134.00
	Бусад мөнгөн зарлага	344,909,390.50	317,684,017.74
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	108,357,308.88	160,797,180.80
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,382,524.71	36,824,102.29
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	20,382,524.71	36,824,102.29
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	19,875,900.00	211,170,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	19,875,900.00	199,290,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		11,880,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтынүйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	506,624.71	(174,345,897.71)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		

Чандмань-Бадрал ОНӨХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	108,863,933.59	(13,548,716.91)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	603,673,872.99	712,537,806.58
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	712,537,806.58	698,989,089.67

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мян.төгрөг/

№	Үзүүлэлтүүд	2020 он		Зөрүү	Биелэлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
A	ОРЛОГО				
1	Дулаан	2,710,284.0	2,745,368.30	35,084.30	101.3%
2	Хэрэглээний халуун ус		5,152.40		
3	Суурь хураамж /дулаан/	93,786.0	97,798.80	4,012.80	104.3%
4	Ус хангамж	508,947.0	485,154.00	(23,793.00)	95.3%
5	Ариутгах Татуурга	268,653.0	254,727.30	(13,925.70)	94.8%
6	Суурь хураамж /УХ-АТ/	80,604.0	83,192.40	2,588.40	103.2%
7	Бусад орлого	228,526.0	324,722.60	96,196.60	142.1%
	Дүн	3,890,800.0	3,996,115.8	100,163.4	102.7%
Б	ЗАРДАЛ				
1	Үндсэн ба нэмэгдэл цалин урамшуулал	1,502,314.0	1,575,362.9	(73,048.86)	105%
2	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	213,389.5	249,441.9	(36,052.42)	117%
3	ТУЗ зардал	35,389.0	23,138.4	(12,250.60)	65%
4	Нүүрсний зардал	760,708.0	770,792.5	10,084.5	101%
5	Цахилгааны зардал	249,816.0	285,770.6	35,954.6	114%
6	Шатахууны зардал	70,471.0	55,799.0	(14,672.00)	79%
7	Материалын зардал	40,956.4	206,960.0	(166,003.60)	505%
8	Сэлбэг хэрэгсэл	32,187.0	8,345.8	(23,841.20)	26%
9	Бичиг хэргийн зардал	7,339.0	7,094.3	(244.70)	97%
10	Хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал	67,789.0	54,064.2	(13,724.80)	80%
11	Их засвар	121,550.0	74,122.3	(47,427.70)	61%
12	Урсгал засвар	31,045.0	9,951.8	(21,093.20)	32%
13	Захиалгат ажлын зардал	26,460.0	7,805.1	(18,654.90)	29%
14	Албан томилолтын зардал	12,000.0	10,755.7	(1,244.30)	90%
15	Сургалтын зардал	31,040.0	5,172.5	(25,867.50)	17%
16	Харилцаа холбооны зардал	10,730.0	6,882.6	(3,847.40)	64%
17	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	9,480.0	11,272.5	1,792.50	119%

Чандмань-Бадрал ОНӨХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

18	Зар сурталчилгааны зардал	380.0	-	(380.00)	0%
19	Гадаад үйлчилгээний зардал	13,785.0	19,673.1	(5,888.10)	143%
20	Бусад зардал	88,590.0	42,354.2	(46,235.80)	48%
21	Гэнэтийн ослын зардал	60,000.0		60,000.00	0%
22	Байгаль орчин хамгаалах зардал	20,000.0	20,000.0	-	100%
	Үйл ажиллагааны зардал	3,405,418.9	3,444,759.4	(39,340.48)	101%
23	Элэгдлийн зардлын дүн	212,368.0	255,100.6	(42,732.60)	120%
24	Орлогын албан татвараас бусад татвар	16,039.0	6,001.8	(10,037.20)	37%
	Бүрэн өөрийн өртөг	3,633,825.9	3,705,861.8	(72,035.88)	102%
25	Бусад орлого		45,163.8	45,163.8	
26	Ажиллагсдын нийгмийн зардал	179,765.5	165,249.9	- 14,515.6	92%
27	Хөрөнгө оруулалт	140,798.0			0%
	Нийт ашиг алдагдал	- 63,589.4	170,167.9	75,428.0	-268%
28	Хөрөнгө оруулалт /тодотголоор орсон/	187,500.0	207,286.0	19,786.0	111%

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Чандмань бадрал ОНӨХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирлын үүрэг гүйцэтгэгч С.Ганцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бэлэн мөнгөний болон бараа материалын дэлгэрэнгүй тайлан гаргах, ажилтнуудын цалин хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос холбогдох хуулийн дагуу татвар шийтгэлийг суутгах, авлага өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 04-нөөс 2021 оны 03 дугаар сарын 14–ний хооронд Есөнхангай Аудит ХХК-ийн аудиторуд Т.Оюунтуяа, Ж.Оюунцэцэг, М.Одцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Чандмань бадрал ОНӨХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит ХХК статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Байгууллагын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан хангамж
- Ус хангамж, ариутгах татуурга
- Инженерийн шугам сүлжээний засвар үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Чандмань бадрал ОНӨХХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогын 3,996.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 79.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Чандмань бадрал ХХК 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 361.6 сая төгрөгөөр буюу 11.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	712.5	699.0	-13.5
Авлага	568.8	738.5	169.6
Урьдчилгаа	0.6	2.8	2.2
Бараа материал	266.7	304.0	37.3
Үндсэн хөрөнгө	1,606.7	1,772.6	165.9
Нийт хөрөнгийн дүн	3,155.3	3,516.9	361.6
Өр төлбөр	43.2	159.7	116.5
Эздийн өмч	3,112.0	3,357.1	245.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,155.3	3,516.9	361.6

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл 738.5 сая төгрөг болж 169.6 сая төгрөгөөр өссөн нь хуучин авлагаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2014-2019 онуудад үүссэн, он удаан жил болсон 169.5 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 304.0 сая төгрөг болж 37.3 сая төгрөгөөр өссөн нь тусгай зориулалттай болон сантехникийн материалын өсөлтөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,772.6 сая төгрөг болж 165.9 сая төгрөгөөр өссөн нь 349.9 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 83.3 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж, 142.0 сая төгрөгөөр элэгдэл нэмэгдэж, хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 41.2 сая төгрөгөөр залруулагдсанаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 159.7 сая төгрөг болж 116.5 сая төгрөгөөр өссөн нь татварын өглөгөөс шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 3,357.1 сая төгрөг болж 245.1 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, ашиг өссөнөөс шалтгаалжээ.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Чандмань-Бадрал ОНӨХХК-ийн дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор Чандмань-Бадрал ОНӨХХК-ийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 3,890.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 3,854.3 сая төгрөгөөр, ашгийг 36.5 сая төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 4,041.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3, 871.1 сая төгрөгийн зардал гарган, 170.1 сая төгрөгийн үйл ажиллагааны ашигтай ажилласан байна.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
2	Нийт орлого	төг	3,746.5	3,890.8	4,041.2	150.4	103.8
	Үүнээс: Цэвэр борлуулалт		3,349.0	3,662.3	3,671.4	9.1	100.2
3	Нийт зардал	төг	3,643.7	3,854.3	3,871.1	16.8	100.4
	Үүнээс: а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		2,668.7	3,031.2	2,990.8	40.4	98.6
	б) Ерөнхий ба удирдлагын зардал		769.4	687.4	786.7	99.3	114.4
	в) Борлуулалт маркетингийн зардал		24.5	23.2	9.6	-13.6	41.0
	г) Хөрөнгө оруулалт их засвар		181.8	112.5	84.0	-28.5	74.6
4	Цэвэр ашиг, алдагдал		102.8	36.5	170.1	133.6	366

Нийт орлогын гүйцэтгэл 4,041.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 150.4 сая төгрөг буюу 3.8 хувиар давж биелсэн нь дулааны шугаманд 9 айл өрх нэмэгдэж, цэвэр усны шугаманд 53 айл өрх холбогдож, аж ахуйн нэгж байгууллагын шугамын ажлыг өргөтгөсөнтэй холбоотой.

Нийт зардлын гүйцэтгэл 3,871.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 16.8 сая төгрөг буюу 0.4 хувиар хэтэрсэн байна. Энэ нь ТУЗ-ийн 2020 оны 01-р сарын 07-ны өдрийн 09 тоот тогтоолын дагуу цалинг 5-10 хувиар нэмсэнтэй холбоотой.

Тайлант онд цэвэр ашиг 170.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 133.6 сая төгрөгөөр илүү байгаа нь нийт орлого 3.8 хувиар давж биелэн, сургалтын зардал 17 хувиар, албан томилолтын зардал 90 хувиар, харилцаа холбооны зардал 64 хувиар, урсгал зардал 32 хувиар, их засварын зардал 61 хувиар хэмнэгдсэнээс тус тус шалтгаалж байна.

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Чандмань бадрал ОНӨХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 9 сарын 17-ны өдрийн 12/73 дугаар тогтоолын шийдвэрээр Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 4, хараат бус 3, нийт 7 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлыг 2020 онд 6 удаа зохион байгуулж 9 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагаа, засаглалтай холбоотой дүрэм, журам шинэчлэн батлагдаагүй байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 25.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 17 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, урамшууллын зардалд 15.4 сая, бусад зардалд 1.6 сая төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож тайлагнасан байна.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт					/сая.төг/
	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	5		4		80
Нийт дүн	5		4		80

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 407.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 235.3 сая төгрөгийн алдааг залруулж, 171.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг бүртгэхдээ орлогоор бүртгэлгүй эзэмшигчийн өмчийн бусад хэсэгт бүртгэснийг НББОУС 20 стандартын дагуу бүртгэж залруулав.

2. Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг давтан шалгахад нэг хөрөнгөнд 30.0 сая төгрөгийн элэгдэл илүү тооцсон байна. Тухайн хөрөнгийн ашиглах хугацааг алдаатай оруулснаас өмнөх тайлант хугацааны элэгдлийг залруулахдаа хөрөнгийг орлогодсон алдаатай бичилт хийснийг залруулав.

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацааны эцэст санхүүгийн тайлангаар дүрмийн сан 846.4 сая төгрөг, улсын бүртгэлийн гэрчилгээгээр 6,494.5 сая төгрөг, компанийн дүрмээр 1,492.7 сая төгрөг байх ба 2019 оны 01 дүгээр сард сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор компанийн дүрмийг шинэчлэн батлахдаа тухайн үед компанийн дансан дахь мөнгөн хөрөнгө, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн дүнгээр дүрмийн сангаа өөрчилсөн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.2.1 “*орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;*” заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Хөрөнгөнд тавих хяналт алдагдах

1.3. Өгсөн зөвлөмж

Дүрмийн санд өөрчлөлт орсон бол өөрчлөлтийн талаарх баримтаа бүрдүүлэн Улсын бүртгэлийн газарт бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, тайлан бүртгэлийг зөрүүгүй болгох

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацааны эцэст харилцагч бүрээр тулган баталгаажуулалт буюу тооцоо нийлсэн акт үйлдээгүйгээс 146.6 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

2.2. Эрсдэл:

Найдваргүй авлага үүсэх

2.3. Өгсөн зөвлөмж

Ерөнхий нягтлан бодогч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" үүрэгтэй тул уг заалтыг мөрдөж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Хөрөнгө бэлтгэхдээ ТУЗ-аар батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй тавилга, компьютер гэх мэт 24.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

3.2. Эрсдэл:

Хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

3.3. Өгсөн зөвлөмж

Хөрөнгө оруулалт худалдан авалтын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөн батлуулж, төлөвлөгөөгөө мөрдөж ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

4. Балансын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Авлагын дансны кредит үлдэгдлийг урьдчилж орсон орлогоор бүртгэдэг ба энэ нь өр төлбөрийн ангилал зөв хуваарилагддаггүйг илэрхийлж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12-р зүйл заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл:

Авлага өр төлбөрийн үлдэгдэл, ангилал алдаатай илэрхийлэгдэх

4.3. Өгсөн зөвлөмж

Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг ангиллын дагуу бүртгэсэн эсэхийг тайлант хугацааны эцэст хянаж байх

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

5. Балансын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Жилийн эцсийн тооллогоор тээврийн хэрэгсэл ангилалд 0.7 сая төгрөгийн мотоцикл тоологдоогүй бөгөөд тооцоо бодсон актаар бүрэн тоологдсоноор оруулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйл заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Эрсдэл:

Хөрөнгө илүү дутуу илэрхийлэгдэх, хяналт алдагдах

5.3. Өгсөн зөвлөмж

Хөрөнгийн тооллогыг бодитой чанартай хийж тооллогын үр дүнгээр холбогдох тооцооллын бичилт хийж акт үйлдэж байх

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Чандмань бадрал ОНӨХХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2021			ДГА-2021/3/СТА-ОНӨААН
Шалгагдсан байгууллагын нэр:	Чандмань бадрал ОНӨХХК		сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг орлогоор бүртгэлгүй эзэмшигчийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн байна.	120.4	Залруулах	Нягтлан бодогч	Ц.Лхагвасүрэн
2	Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг давтан шалгахад нэг хөрөнгөнд 30.0 сая төгрөгийн элэгдэл илүү тооцсон байна. Мөн энэ хөрөнгийг 20 жил ашиглах ёстой байтал 3 жилээр оруулж өмнөх тайлант хугацаанд элэгдлийг алдаатай тооцож байсан ба зөрүүг залруулах бичилт хийхдээ алдаатай хийж, хөрөнгийг дахин орлого авсан байна.	114.9	Залруулах	Нягтлан бодогч	Ц.Лхагвасүрэн
3	Санхүүгийн тайлангаар дүрмийн сан 846.4 сая төгрөг, улсын бүртгэлийн гэрчилгээгээр 6,494.5 мянган төгрөг, компанийн дүрмээр 1,492.7 мянган төгрөг байх ба 2019 онд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор компанийн дүрмийг шинэчлэн батлахдаа тухайн үед компанийн дансан дахь мөнгөн хөрөнгө, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн дүнгээр дүрмийн сангаа тогтоосон байна.	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Лхагвасүрэн
4	Тайлант хугацааны эцэст харилцагч бүрээр тулган баталгаажуулалт буюу тооцоо нийлсэн акт үйлдээгүйгээс 146.6 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. НББ-ийн тухай хуулийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалттай нийцээгүй.	146.6	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Лхагвасүрэн
5	Хөрөнгө бэлтгэхдээ ТУЗ-аар батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй тавилга, компьютер гэх мэт 24.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.	24.4	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Лхагвасүрэн
6	Авлагын дансны кредит үлдэгдлийг урьдчилж орсон орлогоор бүртгэдэг ба энэ нь өр төлбөрийн ангилал зөв хуваарилагддаггүйг илэрхийлж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Лхагвасүрэн

Чандмань-Бадрал ОНӨХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

7	Жилийн эцсийн тооллогоор тээврийн хэрэгсэл ангилалд 754.7 мянган төгрөгийн мотоцикл тоологдоогүй бөгөөд тооцоо бодсон актаар бүрэн тоологдсоноор оруулсан	0.7	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Лхагвасүрэн
ДҮН		407.1			